# ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТЫН ЭРГЭН МЭДЭЭЛЭЛ

## 2026 ОНЫ I УЛИРАЛ

77115333-4
tandalt@gemtel.moh.gov.mn
www.gemtel.mn

# МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ
# 2026 I УЛИРАЛ

2026 оны эхний 3 сарын хугацаанд Монгол Улсын хэмжээнд гэмтэл хордлого, гадны шалтгаант 53 141 шинэ тохиолдол бүртгэгдэж өмнө оны мөн үетэй харьцуулахад 8.7%-иар өссөн байна.



***Осол гэмтлийн шинэ тохиолдол***




***Осол гэмтлийн шинэ тохиолдол, хүйсээр***




Дээрх тохиолдлын 57.2% (30375), 42.8% (22766) эмэгтэй буюу осол гэмтлийн шалтгаант 10 шинэ тохиолдол тутмын 5-6 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй байна.



Нийт тохиолдлын 12.9% буюу 6842 нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртсөн байна.



***Согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх, хувиар***



Энэ оны эхний 3 сарын хугацаанд осол гэмтэлд өртсөн нийт тохиолдлын 36.0% /19154/ 0-18 насны хүүхэд, 64.0% /33987/ насанд хүрэгчид буюу 19+ настай байна. Харин тохиолдлын тоо болон хувиар 10-14 насны хүүхэд хамгийн их хувийг эзэлж байна.

| Насны бүлэг | Тохиолдлын тоо | Хувь |
|---|---|---|
| 0-4 | 4710 | 8.9 |
| 5-9 | 3469 | 6.5 |
| 10-14 | 6317 | 11.9 |
| 15-19 | 5380 | 10.1 |
| 20-24 | 3750 | 7.1 |
| 25-29 | 3718 | 7.0 |
| 30-34 | 4007 | 7.5 |
| 35-39 | 4575 | 8.6 |
| 40-44 | 3784 | 7.1 |
| 45-49 | 3122 | 5.9 |
| 50-54 | 2793 | 5.3 |
| 55-59 | 2238 | 4.2 |
| 60-64 | 1997 | 3.8 |
| 65-69 | 1420 | 2.7 |
| 70+ | 1861 | 3.5 |

Осол гэмтлийн шалтгааны уналт 42.5%-иар тэргүүлж удаах шалтгаануудад амьтай амьгүй хүчин зүйлс өртөх, зам тээврийн осол болон хүчирхийлэл багтаж байна.

| ICD10 | Осол гэмтлийн шалтгаан | Тохиолдлын тоо | Хувь |
|---|---|---|---|
| W00-W19 | Уналт | 22,600 | 42.5 |
| W20-W49 | Амьгүй механик хүчинд өртөх | 9,875 | 18.6 |
| W50-W64 | Амьтай механик хүчинд өртөх | 4,811 | 9.1 |
| V01-V99 | Зам тээврийн осол | 4,705 | 8.9 |
| X85-Y09 | Хүчирхийлэл | 4,650 | 8.8 |
| W85-X19 | Түлэгдэлт | 1,928 | 3.6 |
| X40-X49 | Санамсаргүй хордох, хорт бодист өртөх | 1,666 | 3.1 |
| Y10-Y34 | Тодорхойгүй осол | 1,283 | 2.4 |
| X30-X39 | Байгалийн хүчинд өртөх | 609 | 1.1 |
| X50-X59, Y35-Y98 | Бусад осол | 504 | 0.9 |
| X60-X84 | Амиа хорлохыг завдах | 436 | 0.8 |
| W75-W84 | Амьсгал боогдох | 65 | 0.1 |
| W65-W74 | Усанд живэлт | 9 | 0.0 |

Осол гэмтэлд өртөх үеийн байршлаар харвал хүмүүс гэртээ бэртэж гэмтэх тохиолдол хамгийн их хувийг эзэлж байна. Мөн гудамж, зам болон биеийн тамир спортын талбайд байхдаа гэмтэх тохиолдол түгээмэл байна.




2025 оны I улиралд бүртгэгдсэн осол гэмтлийн нийт тохиолдлын 17.0% (9035) орон нутагт бүртгэгдэж тохиолдлын тоогоор Өвөрхангай, Сэлэнгэ, Дорноговь, Архангай, Төв аймгууд тэргүүлж байгаа бол 83.0% (44106) нийслэл Улаанбаатар хотод бүртгэгдлээ. Харин нийслэлд бүртгэгдсэн тохиолдлын 93.1% (41062) ГССҮТөвийн ЯТТасгаас тусламж үйлчилгээ авчээ.



## МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН БАЙДАЛ 2026I УЛИРАЛ

Монгол улсын хэмжээнд 2026 оны эхний 3 сарын байдлаар осол гэмтлийн шалтгаант 813 нас баралт бүртгэгдсэн байна.







Нийт тохиолдлын 77.4% (629) нь эрэгтэйчүүд бол 22.6% хувь (184) нь эмэгтэйчүүд байна.

Эхний улирлын байдлаар осол гэмтлийн шалтгаант нас баралт 40-49 насанд хамгийн өндөр хувийг эзэлж байна.



Нийт тохиолдлын 61.1% (497) нь гэмтэх үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн байна.




Осол гэмтлийн шалтгаант нас баралтын 42.4% (345) нь хөдөө орон нутагт, 57.6% (468) нь нийслэлд бүртгэгдсэн байна. Нас баралт Сэлэнгэ, Төв, Архангай аймгуудад бусад аймгуудаас өндөр байна.




2026 оны эхний 3 сарын байдлаар санамсаргүй хордох, санаатайгаар өөртөө гэмтэл учруулах, байгалын хүчинд өртөх шалтгаанууд тэргүүлж байна.

| ICD10 | Осол гэмтлийн шалтгаан | Тохиолдлын тоо | Хувь |
|---|---|---|---|
| X40-X49 | Санамсаргүй хордох, хорт бодист өртөх | 316 | 38.9 |
| X60-X84 | Амиа хорлохыг завдах | 135 | 16.6 |
| X30-X39 | Байгалийн хүчинд өртөх | 94 | 11.6 |
| V01-V99 | Зам тээврийн осол | 93 | 11.4 |
| W00-W19 | Уналт | 53 | 6.5 |
| X85-Y09 | Хүчирхийлэл | 48 | 5.9 |
| W75-W84 | Амьсгал боогдох | 26 | 3.2 |
| Y10-Y34 | Тодорхойгүй осол | 18 | 2.2 |
| W85-X19 | Түлэгдэлт | 10 | 1.2 |
| W65-W74 | Усанд живэлт | 9 | 1.1 |
| W20-W49 | Амьгүй механик хүчинд өртөх | 8 | 1.0 |
| W50-W64 | Амьтай механик хүчинд өртөх | 3 | 0.4 |
| | ***Нийт*** | ***813*** | ***100.0*** |